

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.06.17 № 03/5163  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Гомдол хянасан тухай**

Танай байгууллагаас зарласан ОйГ/20240203085 дугаартай “VR технологи ашиглан ойн ангиудын боловсон хүчнийг чадавхжуулах сургалт зохион байгуулах, ойн ангийн үйл ажиллагааг сурталчлан таниулах” үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтад оролцсон “Гэрэгэ дижитал технологи” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Гэрэгэ дижитал технологи” ХХК-ийн ирүүлсэн гомдолд тус компанийн мэдээллийг дутуу хянасан байх тул захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу “Гэрэгэ дижитал технологи” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д “Тендерт оролцогчийн санал болгосон нийт программ хөгжүүлэгч, инженер, техникийн ажилчдын 40-өөс доошгүй хувь нь өөрийн үндсэн ажилтан байна. Санал болгож буй голлох мэргэжилтнүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг тендерт оролцогч төлсөн болохыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаас шалгаж үзнэ. Хэрэв шаардлага хангаагүй бол шаардлагад нийцээгүй тендер гэж үзнэ. Ажил гүйцэтгэх хүний нөөц: Шаардана. Багийн удирдлага, үндсэн хөгжүүлэгч, инженер, туслах инженер, зөвлөх ойн инженер, зөвлөх биологич. Дээрх VR технологийн үндсэн хөгжүүлэгч, сургалт зохион байгуулах ажилтнуудын жагсаалтыг маягт 8-д заасны дагуу гаргана. Хэрэв багийн гишүүд нь гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлэх /хөлсөөр ажиллах гэрээ нь энэхүү төслийн ажилд зориулсан байх бөгөөд захирлын тушаалаар томилсон байх, гэрээний хугацаа, үнийн дүн бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна. Үндсэн болон туслах ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан шалгана. Сүүлийн 3 сар тасралтгүй төлсөн байх шаардлагатай. Үндсэн болон туслах ажилтнуудын бичиг баримтыг дутуу ирүүлэх, нийгмийн даатгалын шимтгэл дээр дурдсан хугацаанд төлөгдөөгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно. Санал болгож буй ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шалгах

тул ажилтны регистрийн дугаарыг ирүүлнэ. Санал болгож буй голлох мэргэжилтнүүдтэй байгуулсан ажил гүйцэтгэх болон хөдөлмөрийн гэрээний хуулбар ирүүлэх.” гэж, мөн ТШЗ 18.2-т “Шаардсан хүний нөөцийн мэдээллийг IV бүлгийн маягт-7 дагуу ирүүлэх.” гэж заасан байна.

1. “Гэрэгэ дижитал технологи” ХХК тендерт 7 дугаар маягтаар багийн удирдлагаар Б.Амартайванг, үндсэн хөгжүүлэгчээр С.Пүрэвдоржийг, инженерээр Г.Төгсбаясгаланг, туслах инженерээр Г.Итгэлийг, зөвлөх ойн инженерээр Д.Туяаг, зөвлөх биологичоор Ё.Ононыг, нэмэлтээр үндсэн хөгжүүлэгчээр Ц.Мөнхжаргал нарыг тус тус санал болгосон байна.

Захиалагч 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Б.Амартайван, С.Пүрэвдорж, Г.Итгэл нарын нийгмийн даатгалын тодорхойлолтыг худалдан авах ажиллагааны цахим системээс хянан үзсэн байна.

Үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлд “...Үндсэн ажилтан Ц.Мөнхжаргал, Г.Төгсбаясгалан нарын нийгмийн даатгал төлөлтийн лавлагааг tender.gov.mn-ээс 3-с дээш удаа лавлагаа татах оролдлого хийсэн ч лавлагаа хоосон төлөвт, мэдээлэл гарч ирээгүй. Иргэний үнэмлэхийн лавлагаа хэсэгт бичигдсэн регистрийн дугаарыг ашиглан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг авах гэж үзсэн...” тухай дурдсан байна.


“Гэрэгэ дижитал технологи” ХХК тендерт Ц.Мөнхжаргалыг үндсэн хөгжүүлэгчээр нэмэлтээр санал болгосон байхад мэдээллийг үнэлгээнд харгалзан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

2. Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.5-д “Захиалагч цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараах журмаар ирүүлсэн тендер шалгаруулалт зарласнаас хойших мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгоно. Үүнд: 2.5.1.татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт. Уг тодорхойлолтыг оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим системээр дамжуулан авч цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбосон байх;” гэж заасны дагуу үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим системээс “Гэрэгэ дижитал технологи” ХХК-ийн тендерт санал болгосон Г.Төгсбаясгалангийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтыг шалгахад мэдээлэл гарч ирээгүй байх тул тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д заасан шаардлагад нийцээгүй гэж үнэлсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Гэрэгэ дижитал технологи” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ